



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2007 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 309

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах, тушаалд
өөрчлөлт оруулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам”, Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт Сургалтын төрийн сангийн зээлээр өөрийн захиалгаар хүн суралцуулах эрх бүхий байгууллагуудын санал, Гадаадын их, дээд сургуульд улсын зардлаар магистрантурт суралцах эрхийн бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ганбат овогтой Бүүвэйхүүг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар АНУ-ын Колорадогийн техникийн их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Гомбо овогтой Сайнхүүг Япон улсын Токио хотын Дайто Вунка дээд сургуулийн магистрантурт мэдээллийн технологийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Тайванхүү овогтой Тэрбишийг ХБНГУ-ын Хонновер хотын Анагаах ухааны дээд сургуулийн магистрантурт эрүүл мэндийн менежментийн чиглэлээр 1 жилийн хугацаагаар, Бэгз овогтой Мөнхбаярыг Байгаль орчны яамны захиалгаар Англи улсын Лондонгийн Худалдааны сургуулийн магистрантурт эдийн засгийн чиглэлээр 1 жилийн хугацаагаар, Ринзаан овогтой Дэжидийг Батлан хамгаалах яамны захиалгаар АНУ-ын Стрэйер их сургуулийн магистрантурт төрийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Жүгдэр овогтой Отгонбаатарыг Эрүүл мэндийн яамны захиалгаар Япон улсын Осакагийн их сургуулийн магистрантурт эх барих, эмэгтэйчүүдийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Билэгт овогтой Лхагвасүрэнг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын захиалгаар АНУ-ын Stratford их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Батбаатар овогтой Мөнхсайхан, Бямбасүрэн овогтой Батболд нарыг Онцгой байдлын ерөнхий газрын захиалгаар ОХУ-ын Гал эсэргүүцэх албаны академид 2 жилийн хугацаагаар тус тус 2007-2008 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Манжилжав овогтой Баттулгыг Канад улсын Маласпина их сургууль коллежийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 1,5 жилийн хугацаагаар 2007-2008 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 249 дугаар тушаалын Олзвой овогтой Энхбаттай холбогдолтой хэсгийн “АНУ-ын Калифорнийн Улсын их сургууль” гэснийг “АНУ-ын Де Врай их сургуулийн Келлер менежментийн сургууль” гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 247 дугаар тушаалын


Дашдондов овогтой Батхуягтай холбогдолтой хэсгийн "АНУ-ын Калифорнийн Улсын их сургууль" гэснийг "АНУ-ын Де Врай их сургуулийн Келлер менежментийн сургууль" гэж тус тус өөрчилсүгэй.

4.Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

5.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан 2007 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 270 дугаар тушаалын Дашдорж овогтой Наранжаргалтай холбогдолтой хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Дэд тушаалд кодификаци...





Ө.ЭНХТҮВШИН